



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2018 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/253

Булган

┌ Бэлчээр хамгаалах арга хэмжээг ┐
зохион байгуулах тухай

Монгол Улсын “Ургамал хамгааллын тухай хууль”-ийн 10 дугаар зүйл 10.1.1, Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/31 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баян-Агт, Баяннуур, Булган, Рашаант, Дашинчилэн, Гурванбулаг, Могод, Хишиг-Өндөр, Бүрэгхангай, Орхон, Сайхан сумдын бэлчээрийн 50.0 мянган га талбайд байгаль орчинд халгүй аргаар үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг энэ оны 05 дугаар сарын 01-нээс 06 дугаар сарын 20 хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Уг арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг сайтар хангаж, үлийн цагаан оготно ихээр тархсан бэлчээр нутгийн малчдын хүчийг оновчтой зохион байгуулж, чанарын өндөр түвшинд гүйцэтгэхийг холбогдох сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх талаар сумын Засаг дарга нартай гэрээ байгуулж, хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулахыг Хүнс, Хөдөө аж ахуйн газар /Ч.Амгалан/-т, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Долгорсүрэн/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ